

## БРАХМАСУТРА ВЕДАНТА ФИЛОСОФИЙН ЭХ СУРВАЛЖ БОЛОХ НЬ

Б.Мөнхжавхлан (Доктор Ph.D)  
Б. Дагзмаа (Доктор Ph.D)  
Философи, шашин судлалын тэнхим, МУИС

**Түлхүүр уг:** *Брахмасутра, брахман, атман, жинхэнэ бодит байдал, бурхан тэнгэр, бодгалийн оршихуй, мокша, би, сансар, карма, Вед, феноменал өртөнц, мэдлэг, зовлон, эрх чөлөө, аз жаргал*

Энэтхэгийн философиийн үндсэн чиглэлүүдийн нэг болох Веданта философи тус үндэстний соёлын үнэт өв болох эртний судруудын агуулгад үндэслэсэн бөгөөд өвөрмөц сэтгэлгээ, бодрол, бясалгалыг илтгэсэн үлэmj өргөн агуулгатай юм. Энэ философи сургуулийн үзэл санааны эх сурвалж бол Праштана Трай буюу Упанишад, Бхагвад Гита, Брахмасутра гэсэн гурвалсан том судрууд бөгөөд энэхүү өгүүлэлд Брахмасутра буюу Веданта сутрын тухай өгүүлэх юм.

Ведийн зорилго болох брахман бол жинхэнэ бодит байдал мөн гэсэн үзлээс үүдэж Ведантасутра бичигдсэн бөгөөд үүнийг энэтхэгийн философиийн түүхэнд Брахмасутра, Уттармимансасутра, Сариракасутра, Биксүсугтра гэж янз бүрээр нэрлэдэг. Брахмасутраг брахманы талаарх сургаалыг илэрхийлдэг гэдэг утгаар, Сариракасутраг “би биелэлээ олсон” тухай агуулгыг илэрхийлдэг гэж, Биксүсугутраг “хуврагт зориулсан судар” гэсэн утгаар хэрэглэдэг боловч угтаа нэг судар юм. Сэтгэгчид энэ судрын агуулгад өөр өөр байр сууринаас тайлбаруудыг хийснээр бие даасан философи сургууль үүссэн байна. Тухайлбал Веданта философиийн гол сэтгэгчид болох Шанкара (МЭ VIII), Раманужа (МЭ1017-1137), Мадхва (МЭ1199-1278) нарын тайлбар бүтээл нь тэдний философи үзлийг илэрхийлнэ. Тэд бүгд Бхагвад Гита, Брахмасутра, Упанишадад тайлбар хийж, улмаар өөрсдийн бие даасан философи үзлийг боловсруулсан байдал.

Түүхийн үүднээс авч үзэхэд цаг хугацааны хувьд Веданта, Упанишадаас хойш бий болсон бөгөөд бичгийн эх сурвалж нь Упанишадын бүтэцтэй адилхан ажээ. Уг зохиолыг эртний гэгээнтүүд болох Бадарайна, Кришна, Двапайяна, Въяса (заримдаа Бадарайнаг Въясагийн шавь гэх) бичсэн гэж үздэг. Тус судар МЭ II зууны үед бичигдсэн байж болзошгүй юм. МЭ 400-450 оны үед эмхлэгдэж үндсэн хэлбэртээ орсон гэж зарим сурвалжид тэмдэглэгджээ. Брахмасутраг хэн зохиосон болон хэдий үед бичигдсэн талаар баттай баримт байдаггүй. Тухайлбал Бадарайна, Въяса нарыг зохиогч нь гэж үздэг. Гэтэл хожмын тайлбарлагчид Бадарайна, Въяса хоёрыг нэг хүн гэж үзсэн тохиолдол бий. Мөн Въясаг Веданта философиийг уламжлан дэлгэрүүлсэн гэх болсон байна. МЭ 780-аад оны үед Гаудапада Мандукья Упанишадад тайлбар хийж Мандукъякарика зохиолыг бичсэн, түүний шавь болох Говинда, мөн Говиндагийн шавь Шанкара нар уламжлан тайлбарласан гэж үзэх явдал бий. Харин Адвайта Ведантаг үндэслэгч Шанкара нь Бадарайна, Въяса хоёрыг адилтгаж үзээгүйгээр барагүй Въясаг энэтхэгийн эртний туульсын нэг болох Махабхаратыг, харин Брахмасутраг Бадарайнаг бичсэн гэж үзэж байна. Гэвч Брахмасутрын агуулгад Бадарайнагийн өөрийн онолын тайлбарууд байдгаас хараад судрын зохиогч нь Бадарайнагаас өмнө амьдарч байсан мэт байна. Зарим тайлбарт гуравдагч хүний зүгээс өөрийн зохиолоо бичиж, зохиолдоо нэрээ өгөх явдал түгээмэл байсан гэж судлаачид бичдэг. Энэхүү өгүүллийг

бичигчдийн судлахаар сонгож авсан бүтээлүүдэд Бадааянаг Брахмасутрагийн зохиолч мөн хэмээн тэмдэглэсэн байна. (M.Hiriyanna, 336)

Брахмасутрад бодит байдал болох брахман, бодгаль хүний амьдрал, сансар, карма, брахманд хүрэх арга замын тухай авч үздэг юм. Түүний эх сурвалж нь Упанишад бөгөөд тус сударт олон Упанишадын агуулга давтагдсан байдаг. Ер нь Брахмасутра бичигдсэнээр Вед, Упанишадын агуулга тодорхой болсон гэж уг зохиолын хувь нэмрийг дorno дахиныг судлаачид үnэлдэг.

Ерөнхий бүтцийн хувьд 555 сургаал угс буюу афоризм, 4 бүлэг (*adhyāya*), бүлэг тус бүр 4 хэсэгтэй (*pāda*). Хэсэг бүр нь дэд хэсгүүдтэй (*adhikarana*). Эдгээр дэд хэсгүүд нь олон тооны бичвэрээс бүтэх бөгөөд судрын тоог Шанкара 535 гэсэн бол Мадхва 564 хэмээсэн байна (Rao, 1976). Брахмасутра цөөхөн үгнээс бүтэх өгүүлбэрээр томъёологдсон бөгөөд тэдгээр өгүүлбэр нь өргөн утга бүхий ажээ. Утгыг нь олон сэдэвт хамруулан тайлбарлаж болох аж.

Мөн Брахмасутраг Упанишадуудын агуулгыг системчлэх зорилгоор тус бүртээ 2-3 үгнээс бүтэх 555 судрыг бичсэн бөгөөд нэмэлт тайлбаргүйгээр нэг ч судрын утгыг ойлгох аргагүй, түүнд ач холбогдолгүй уг нэгээхэн ч үгүй гэж судлаачид үздэг. Тийм ч учраас мөн Нирнаяака шастра (*nīrnāyaka sāstra*) гэж нэрлэдэг. Ерөнхий агуулгын хувьд:

**Саманвая** (*Samanvāya*) хэмээх I бүлэгт амьдралын гол зорилго болох Брахманы тухай буюу жинхэнэ бодит байдлын тухай өгүүлнэ. Брахманы мөн чанар, бодгалийн ухамсартай хэрхэн холбогддогийг энд авч үздэг. Энд ертөнцийн анхдагч шалтгаан болох брахман өөр бусад категориудын тухай Упанишадуудаас эш авч бичсэн байдаг.

**Авиродха** (*Avirodha*) хэмээх II бүлэгт Веданта чиглэлийн философи үзлийн эсрэг үндэслэлүүдийг илэрхийлж бичжээ. Энд эмпирик ертөнц, түүний мөн чанар нь бурхан тэнгэрээс ангид байх талаар өгүүлдэг бөгөөд эмпирик ертөнц хэрхэн бурхан тэнгэрт холбогдог эсэх, бие, түүний үйлийн тухай асуудал бас энд гардаг билээ.

**Садхана** (*Sadhbāna*) хэмээх III бүлэгт бодит байдлыг хэрхэн таних, эзэмших тухай бичсэн байна. Браhma видьяг хэрхэн эзэмших, арга зам болон хэрэгслийн талаар өгүүлж, дахин төрөл авахуй хийгээд, сэтгэл зүй, теологийн асуудлыг энд мөн авч үздэг юм.

**Пала** (*Phāla*) хэмээх IV бүлэгт бодит байдлыг танин барьсан тухай, тэрхүү төлөв байдлын тухай өгүүлнэ. Сүнс биеэс хэрхэн ангижрах, дахин төрөл авахгүй байх талаар энд бичсэн байдаг. Мөн чөлөөлөгдсөн байдал болох *moksha*, түүний мөн чанарын тухай өгүүлжээ.

Брахмасутрад Брахман мөнх, бүтээгдээгүй, бөгөөд орчлонгийн шалтгаан юм. Бүх л материаллаг элементийг брахман бүтээсэн. Ертөнц дээр өөрчлөлт, хувьсал бий болж байгаа нь түүнийг бүрдүүлэгч анхдагч элементүүдийн идэвхтэй үйл ажиллагаа бөгөөд, энэ хувьсалд брахман нөлөөлж байгаа юм. Элементүүдийг бүтээснийхээ дараа брахман тэдгээрт оршиж мөн тэдэнд нөлөөлж байдаг гэж бичсэн байдаг. Үүнийг зүйрлэхдээ, алтэсвэл шавраар ямарваа зүйлийг урлахад тухайн юмст хэлбэр нь хэдий өөр өөр болох боловч бүгдэд алт, шавар өөрөө шингэмэл байдаг лугаа адил брахман хaa сайгүй орших ажээ гэсэн байна. Брахмасутрад ертөнцийн шалтгаан бол брахман гэж үзээд, түүний тухай мэдлэг нь хамгийн дээд мэдлэг гэж үздэг. Мөн Брахманыг оюунаар биш харин судар бичгээр танин мэднэ гэсэн байдаг билээ. Брахмасутрад Ведийг “*śruti*” буюу абсолют дээд хэмээн үзсэн нь Ведийн судрын агуулгыг үнэн хэмээгсдэд үлэмж гүн агуулгатай, харин түүнд эргэлздэг хүний хувьд тодорхой утга үгүй байв. Энэ бүхэн нь интуицийн мэдлэгийг чухалчлах, улмаар шабда буюу итгэмжийн мэдлэг бол мэдлэгийн найдвартай, баттай эх сурвалж гэж үздэгийн гол үндэслэл болдог билээ. Энэ үзэл санааг Ветанта философиин чиглэлүүд уламжилсан байдаг.

Сударт өгүүлснээр хэдий эртний сурвалж бичгүүдийн тайлбарууд бие биеэсээ ялгаатай боловч эцсийн дүндээ цор ганц брахманыг л тайлбарлахыг эрмэлзсэн ажээ.

Брахмасутрад, бүтээгдсэн ертөнцийн хэлбэрийн шалтгааныг *shabda* буюу “*үг*”

юм гэсэн байдаг. Үг бол зөвхөн авиа, хэл яриа төдий биш харин үзэгдлийн ертөнцийн бүх юмыг өөрийн оршихуйтай болгодог чадавхтай.

Брахмасутрад, брахманаас хэрхэн феноменал ертөнц үүсч хөгжсөн болон үүний шалтгааны талаар өгүүлсэн байдаг. Брахмасутраг зохиогч хэлэхдээ, ертөнцийн хөгжлийн асуудал нь дан ганц брахманаас хамааралтай. Жишээ нь, сүү нь тараг болж хувирдаг шиг Бурхан тэнгэр бас гадны оролцоогүйгээр юмыг бүтээдэг гэжээ.

Харин Брахмасутрад “сүнслэг оршихуйгаас материаллаг зүйл бий болсон баримт ертөнцөд бий. Жишээ нь: үс, хумс хүнээс ургадаг, бас сүнслэг зүйл материаллаг зүйлээс гардаг. Хорхой шавьж үхрийн аргалаас гардаг. Эндээс харахад сүнслэг брахман материаллаг ертөнцийг бий болгох нь иррациональ зүйл биш юм” гэсэн байдаг (БС.П.1.6).

Мөн ертөнцийн юмс устаж үгүй болохдоо брахманд шингэдэг үү гэсэн асуулт гарч ирдэг. Ваар, шил хагарахдаа тоос болон хувирч, хэлбэр нь үгүй болно гэсэн хариултыг Брахмасутрад өгүүлжээ. Мөн таван элементийн хөгжлийн дараах байгалийн ертөнцийн хэлбэржилтийг Брахмасутрад ертөнц шороо, ус, гал гэсэн гурван элементийн нэгдлээр бий болжээ гэсэн байдаг. Гэхдээ эдгээр элементүүдийн орц, бүрэлдэл нь өөр өөр байдаг. Жишээ нь шороонд ус, чийг гал байх боловч шороо давамгайлах шинжтэй гэх мэтчилэнгээр материаллаг ертөнцийн бүрэлдлийг тайлбарладаг байна. Өдөр тутмын амьдралд бидний мэдэрч буй зүйлс бас эдгээр элементүүдийн хослол юм. Хүний биеийн хувьд ч ялгалгүй оюун ухаан, махбод бугд шорооны мөн чанартай, шээс, цус, амьсгал бол усны мөн чанартай, яс, хэл, яриа нь галын мөн чанартай гэх мэтээр хосолж байдаг.

Феноменал ертөнц бол цаг хугацаагаар хязгаарлагддаг, мөнх бус, төгс бус, ариун бус байдаг.(БС.П.1.8)

Гэхдээ өдөр тутмын амьдралдаа мэдэрч буй гадаад объектуудыг бид хуурамч гэж үздэггүй. Энэбол Брахмасутра дахь хамгийн чухал онтологи санаа юм. Тийм ч учраас бодгалийн оршихуй, түүний чөлөөлөгдхөн байдлын тухай үзэл баримтлал энд гарч

ирдэг. Материаллаг буюу феноменал ертөнцөд бодгаль “би” оршиж өөрийн жинхэнэ мөн чанараа нээхийг эрмэлзэж байдаг нь түүний оршихуйн утга учир, Ведантын үзэл санааны үндэс болж байдаг.

Бодгалийн чөлөөлөгдсөн байдал гэдэг бол хамгийн гол зорилго бөгөөд бодгаль “би” агуу хүчийг ойлгон ухамсарлаж, аз жаргалыг мэдэрч байдаг. Брахманы ертөнцөд хүрнэ гэдэг бол чөлөөлөгдсөн байдал юм. Чөлөөлөгдсөн байдлыг зөвхөн дараах амьдралд олж авна. Энэ насанд хэрэгжих боломжгүй. Энэ мэтээр Брахмасутра жинхэнэ бодит байдал, материаллаг ертөнцийн үүсэл, хүний оршихуйн зорилго гэх мэт онтологи гол асуудлын хүрээнд бичигдсэн байна.

Брахмасутраболнэгталаас философиин асуудлуудыг өргөн хамарсан утгатай, нөгөө талаас шашны мистик шинжийг агуулсан байдаг. Энэ нь дараагийн философи чиглэлүүд хөгжих үндсэн шалтгаан болж өгсөн юм.

Жишээ нь Раманужагийн (МЭ1017–1137) үндэслэсэн Вишишта Веданта философи үзлээр “ертөнц”, “би”, “Бурхан тэнгэр” гэдэг ойлголтууд бүгд бодитой ажээ. Жинхэнэ бодит байдал бол ухамсаргүй матери, ухамсарт сүнс, бурхан тэнгэрээс хамааралтайгаар тодорхойлогдоно (Satischandra & Datta 1984, 346). Бурхан тэнгэр субстанц бөгөөд бусад юмс гагцхүү түүний атрибут ажээ. Гэхдээ субстанц, атрибуттай салшгүй холбоотой. Атрибут бие даан үүсч чадахгүй бөгөөд субстанцаас шууд хамааралтай байна. Энэхүү субстанц, атрибутийн нэгдмэл байдлыг *विशिष्टा* гэдэг. Ийнхүү Бурхан тэнгэр, бодгаль сүнс хоорондоо нягт уялдаа холбоотой, бодгалиудыг Бурхан тэнгэрийн бие хэмээн тэрээр тодорхойлсон юм. Эндээс бид Раманужаг ертөнцийн феноменал байдлыг үгүйсгэдэг үзэлтэй байсан гэж дүгнэж болно.

Тэрээр хэдий хүн бодит байдлыг сүсэг бишрэл, бурхан тэнгэрт өөрийгөө зориулснаар танин мэдэж болох боловч хэзээ ч брахманд нэгдэж чадахгүй, брахман ямагт бодгалиас дээгүүр байдаг гэж үздэг. Харин Двайта чиглэлийн үндэслэгч Мадхва (МЭ1238–1317) бурхан тэнгэр, “би”, ертөнц бүгд бие даан оршдог гэж үзсэн.

Гэхдээ “би” хийгээд өртөнц нь Бурхан тэнгэрээс хамааралтай юм (Satischandra & Datta 1984, 373). Бурхан тэнгэр бүх “би”-гийн дотоод чиглүүлэгч имманент зүйл бөгөөд материаллаг өртөнцийн хувьд трансценденталь зүйл юм. Тэрбээр бурхан тэнгэр, бодгаль “би”, материйг хоорондоо ялгаатай гэжээ. Түүнийхээр матери бол тусдаа бодит ахуй байдаг. Мадхвагийн үзлээр, “өртөнц дэх бүх юмс амьд организм бөгөөд бодгаль “би” хоорондоо ялгаатай” ажээ (Radhakrishnan 1992, 743). “Би” бол бурхан тэнгэрээс хамааралтай, хязгаарлагдмал гэдэг утгаараа абсолют бодит байдал биш юм.

Эдгээр философичийн үзэл баримтлалыг товчон илэрхийлэхэд тэдний үзэл брахманыг абсолют бодит байдал гэж үзээд “жива” буюу бодгаль сүнсийг өөр хоорондоо ялгаагүй гэж үздэг хандлага нийтлэг байна.

Эндээс харахад уг судар Веданта философиийн ургсал чиглэлүүд үүсэн гарахад хамгийн чухал эх сурвалж болсон нь гарцаагүй бөгөөд бие даасан зохиол байдлаараа ч судалгааны чухал сурвалж бичиг болох нь харагдаж байна. Брахмасутра цөөн үг, заримдаа ганц өгүүлбэрээс бутдэг, гүнзгий утгатай, мөн шид домгийн тайлбаруудаар баяжсан байdag тул эдгээрт шашны мистик утгад суралцахаас гадна философиийн герменевтик, хэлний философиийн арга зүйгээр задлан шинжлэх өргөн бололцоо байгаа нь харагдаж байна.

## НОМ ЗҮЙ

1. Бхактиведанта Свами Прабхуда. (2010). *Бхагавад Гита анх айлдсан тэр байдлаараа*. Улаанбаатар: Бхактиведанта Бук Траст хэвлэлийн газар.
2. Шри Шри Рави Шанкар. (2015). *Кена Упанишад Тэнгэрлэгийн нууц*. Шри Шри Итгэмжит хэвлэлийн газар. Улаанбаатар.
3. Эрдэнэбаяр, Б. (2012). Ухлийн нууц тэргүүтэн. Ката, Иша, Кена, Прашна, Мандукья, Мундака Упанишад судрууд. Улаанбаатар.
4. BrahmasutraRetrieved; <http://www.yoga-breathing.com/?s=Vedantasutra+PDF>

5. Chatterjee, S., Datta,D. (1984). *An introduction to Indian Philosophy*. Delhi: Calcutta Narayan Press.
6. Dasgupta, S. (2000). *A History of Indian Philosophy*, vol. 1, New Delhi: MotilalBanarsidas Publishers.
7. Deussen, P. (2005). *The Philosophy of the Upanishads*. New Delhi: MotilalBanarsidass Publishers.
8. Hiriyanna, M. (1994). *Outlines of Indian Philosophy*. India.
9. Muller, M. F. (2000). *The Sacred Books of The East: The Upanishads: Part 1. (Volume 1)*. India.
10. Nakamura, H. (1990). *A History of Early Vedānta Philosophy*. (Part I). India. Motilal Banarsidass.
11. Nakamura, H. (2004). *A History of Early Vedānta Philosophy*. (Part II). India. Motilal Banarsidass.
12. Radhakrishnan, S. (2008). *Indian Philosophy*. New Delhi.
13. Radhakrishnan, S. (1992). *Indian Philosophy* (Centenary Edition. Volume Two). New Delhi.
14. Radhakrishnan, S., Moore, C. A.(1981). *A Sourcebook in Indian Philosophy*. United States of America.
15. Rao, N. (1976). *Fundamentals of Indian Philosophy*. India.
16. Sharma, C. (1983). *A Critical Survey of Indian Philosophy*. New Delhi: Motilal Banarsidas Publishers.
17. Thibaut, G. *Vedanta Sutra*.Retrieved; <http://www.sacred-texts.com/hin/sbe34/index.htm>
18. Vatsyayan, (1983). *Indian Philosophy*, New Delhi: KedarNath Ram Nath.

## ABSTRACT

In this paper authors will try to show why the Brahmasutra as ancient great scripture becomes the source of Vedanta philosophical tradition. In the history of Indian thought three scriptures has been considered as primary source of Vedanta philosophy as follows; Brahmasutra, Bhagavad Gita and Upanishad. And in these scriptures, theological and philosophical teachings emerged and thinkers such as Shankara, Ramanuja and others studied and founded several school of thoughts.